



ЭРҮҮЛ МЭНДИЙГ  
ЦЭНЭГЛЭСЭН 10 ЖИЛ

2022 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН



2  
0  
2  
2

# АГУУЛГА

- ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ
- ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
- АЛСЫН ХАРАА, ҮНЭТ ЗҮЙЛС
- КОМПАНИЙН ТҮҮХЭН ТОВЧОО
- ШИНЭ БОЛОН ШИНЭЧЛЭГДСЭН БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД
- САНХҮҮГИЙН ТАЙЛАН МЭДЭЭЛЭЛ
- ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД
- НИЙГЭМД ҮЗҮҮЛСЭН ЭЕРЭГ НӨЛӨӨ
- ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД
- МFC 2.0 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА



## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт хэрэглэгчид, хамтран ажиллагч түнш байгууллагууд, хувьцаа эзэмшигчид, ажилтнууд та бүхнийхээ амар амгаланг айлтган мэндчилж байна.

Монос Хүнс ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны тайланг хүргэж байгааг хүлээн авна уу.

Өнгөрөгч 2022 онд бид бүхний 10 жилийн ой тохиосон, өнгөрсөн хугацааны ололт амжилтаа дүгэн, цаашдын ирээдүйгээ тодорхойлон хэлэлцсэн онцлог жил байлаа.

Манай хамт олон 2022 онд борлуулалтаа өмнөх оноос 50%, цэвэр ашгаа 57%-аар тус тус өсгөж улсын төсөвт 2.2 тэрбум төгрөгийн татвар төлж, шинээр 6 брэндийн 14 нэр төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай байршуулж ажиллажээ.

ОХУ-ын зах зээлд үйл ажиллагаа явуулж буй "TSC Food Products RU" компанитай хамтран "МИЛИНО" брэндийн ааруултай үрэл бүтээгдэхүүнийг хөгжүүлж, харилцагчдаа нийлүүлж эхлээд байна

Түүнчлэн Бүгд Найрамдах Кыргыз улсын зах зээлд нэвтрэх зорилгоор тус улсад Монос групп нь Монос Кэй Жи салбар компаниа байгуулж, тус компанитай хамтын ажиллагаагаа эхлүүлээд байна.

Компанийн цаашдын өсөлт хөгжлийг хангах, эрүүл мэндийн шингэн, хуурай хүнсний үйлдвэрүүдийг нэгтгэх зорилготой MFC 2.0 төслийг амжилттайгаар эхлүүлэн 2023 оны 2-р хагаст ашиглалтад оруулахаар зорин ажиллаж байна.

Ингэснээр шингэн хүнсний үйлдвэрлэлийн хүчин чадал 2.5 дахин, VITOS брэндийн автоматжуулалтыг шийдсэнээр бүтээмж 50%-аар өсөж, 2 үйлдвэр болон алба нэгжүүдийн үйл ажиллагааг нэг доор төвлөрүүлэх юм.

Монос Хүнс ХК нь Тогтвортой хөгжлийн зорилтод өөрсдийн оруулж чадах хувь нэмрийг тодорхойлон дараах чиглэлийн ажлуудыг хэрэгжүүлж эхлээд байна.

- Эрэгтэйчүүдийн эрүүл мэндэд чиглэсэн "ХЭНЭГТЭЙ МОНГОЛ ЭР ХҮН" нийгмийн нөлөөллийн төсөл;

- Байгаль орчны бохирдол, хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор илүү эрүүл, илүү бага хаягдал бүхий сав баглаа боодлын шийдлүүд;

- Нээлттэй, шударга, ёс зүйтэй үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх зорилгоор ESG буюу Нийгэм, байгаль орчин, засаглалын тайлагналыг хэвшүүлэх;

Ингэснээр манай компани нийгэмдээ өгөөжтэй, хувьцаа эзэмшигчдэдээ ашигтай, хэрэглэгчдэдээ ээлтэй урт удаан хугацаанд тогтвортой ажиллах боломжтой болно.

Эрүүл мэндийг цэнэглэсэн 10 жилд хамтдаа байсан эрхэм хэрэглэгчид, харилцагчид, хувьцаа эзэмшигчид, нийт ажилтнууддаа талархал илэрхийлж, Эрүүл мэндийг түгээх ирээдүйн он жилүүдэд хамтдаа хөгжихийг хүсэж байна.

А.Отгондарь  
Монос Хүнс ХК-ийн Гүйцэтгэх захирал

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

## ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮД



**Х.Ананд**  
ТУЗ-ийн дарга  
Монос Групп ХХК  
Гүйцэтгэх захирал



**Л.Хүрэлбаатар**  
ТУЗ-ийн гишүүн,  
Хөдөлмөрийн баатар, доктор,  
профессор, академич, Эрүүлийг  
хамгаалах гавьяат ажилтан  
Монос Групп ХХК Ерөнхийлөгч



**Х.Солонго**  
ТУЗ-ийн гишүүн  
Монос Косметик ХХК  
ТУЗ-ийн дарга



**Ц.Цэцэгбадам**  
ТУЗ-ийн гишүүн  
Монос Групп ХХК  
Санхүү эрхэлсэн захирал



**А.Отгондарь**  
ТУЗ-ийн гишүүн  
Монос Хүнс ХК  
Гүйцэтгэх захирал



**Ч.Баттогтох**  
ТУЗ-ийн гишүүн  
АУ-ны доктор, дэд профессор  
АШУИС-ийн тэнхимийн эрхлэгч

## ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД



**Б.Гантулга**  
ТУЗ-ийн хараат бус гишүүн  
Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх  
хорооны дарга,  
Улаанбаатар үнэт цаасны бирж  
Гүйцэтгэх захирал



**О.Лхагвасүрэн**  
ТУЗ-ийн хараат бус гишүүн  
Аудитын хорооны дарга,  
Сэцэн Билгүүн ХХК  
Гүйцэтгэх захирал



**Ш.Алтанбагана**  
ТУЗ-ийн хараат бус гишүүн,  
Стратеги, бизнес хөгжлийн хорооны  
дарга  
Тера Экспресс ХХК  
Гүйцэтгэх захирал

## ЭРХЭМ ЗОРИЛГО



Эрүүл мэндийг дэмжсэн хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэгчийн сэтгэл ханамжид нийцүүлэн, олон улсын стандартаар **ҮЙЛДВЭРЛЭГЧ, ЭКСПОРТЛОГЧ**, дотоодын зах зээлд **ТЭРГҮҮЛЭГЧ** компани байна.

## АЛСЫН ХАРАА



**ЭРҮҮЛ** мэндийг дэмжсэн **ОРГАНИК** хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэгчдийн өдөр тутмын хэрэглээнд хэвшүүлнэ.

## ҮНЭТ ЗҮЙЛ



Эрүүл чанартай  
Бүтээгдэхүүн



Эрхэм Хэрэглэгч



Итгэлтэй Харилцагч



Ёс зүйтэй Бизнес



Мэдлэг чадвартай  
бүтээлч Хамт олон



Шинэ санал Санаачилга



Монгол Оюун Сэтгэлгээнд  
хөрөнгө оруулагч

# КОМПАНИЙН ТҮҮХЭН ТОВЧОО

Монос Хүнс ХК нь 2012 оноос хүн амын эрүүл мэндийг дэмжих хүнс, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэн худалдаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Бид үндэстний онцлогтой уламжлалт цагаан идээ болон Монгол орны хөрсөнд ургасан анагаах удвистай түүхий эдийг ашиглан тэргүүлэх зэргийн эрдэмтэн судлаачдын олон жилийн судалгаанд үндэслэн бүтээгдэхүүнээ үйлдвэрлэдэг. Нийт 13 брэндийн 71 төрлийн эрүүл мэндийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж Монгол орны 4 зүг найман зовхист бараа бүтээгдэхүүнээ хүргэх үүднээс нийслэл, 21 аймгийн нийт 6.000 цэгт түгээж байна.



## 2012

Монос Фарм ХХК-аас өрх тусгаарлаж, Монос Хүнс ХХК албан ёсоор үүсгэн байгуулав.

Шилэн савлагаатай Цэнэг эрүүл мэндийн бэлдмэлийг үйлдвэрлэлд нэвтрүүлэв.

## 2013



## 2014

ODOO ERP /Enterprise Resource Planing/ системийг компанийн үйл ажиллагаанд нэвтрүүлэв.

## 2016

Монгол Улсад анх удаа Эко уусдаг цайг үйлдвэрлэж эхлэв.



Монгол Улсад анх удаа Экос рН8.5 зөөлөн шүлтлэг усыг үйлдвэрлэв.

## 2015

# 2020

Хүнсний үйлдвэрийн нэгдсэн удирдлагын тогтолцоо **ISO22000:2018** болон Хүний нөөцийн менежментийн **ISO:30400** стандартыг нэвтрүүлэх төслийг эхлүүлэв. Эрүүл Мэндийн Шингэн хүнсний үйлдвэрийг ашиглалтад оруулан, 8 нэр төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэв.



# 2018

БНХАУ болон Япон улсын зах зээлд бүтээгдэхүүнээ байршуулснаар албан ёсоор экспортын гараагаа эхлүүллээ.



Vitos брэндийн Цэнэг эрүүл мэндийн бэлдмэлийг шинэчлэн зах зээлд амжилттай байршуулав. Мөн тус брэндийн "Shot" 3 нэр төрлийн биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн гаргалаа.

Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан IPO гаргаж нээлттэй Хувьцаат Компани болов. Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо **ISO9001:2015** болон Хүнсний аюулгүй байдлын **HACCP** стандартуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж Олон улсын аудитын SGS компаниар баталгаажуулж гэрчилгээгээ гардан авав

# 2021



# 2019

Чанарын удирдлагын тогтолцоо болох **ISO9001:2015** болон Хүнсний аюулгүй байдлын **HACCP** стандартыг нэвтрүүлэх төслийн ажил эхлэв.

"TSC" компанийн ОХУ дахь салбар "TSC Food Products RU" компанитай хамтран "МИЛИНО" брэндийн ааруултай үрэл бүтээгдэхүүнийг хөгжүүлэн, нийлүүлж эхлэв.



# 2017

# 2022



# ШИНЭ БОЛОН ШИНЭЧЛЭГДСЭН БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД



## ЭНХЖИН | ЭРҮҮЛ МЭНДИЙН ЦАЙ савлагаагаа шинэчилж байгальд ээлтэй боллоо

Эмийн ургамалтай Энхжин эрүүл мэндийн цайны сав баглаа боодолд ашиглагдаж байгаа гялгар уутны хэрэглээг 90%, цаасны хэрэглээг 42%-аар бууруулан шинэчилсэн савлагаатайгаар худалдаанд гаргав. Ингэснээр бид жилдээ 8 тонн гялгар уут, болон цаасны хог хаягдлыг бууруулах боломжтой болсон юм.



## “ТАЙЛАГЧ” ХУДАЛДААНД ГАРАВ

Монголын бүтээлч салбарт үнэтэй хувь нэмэр оруулагч, Монгол соёлыг дэлхийд таниулах зорилгоор ЭКОНТЭ ХХК-ийн Хандгай төсөлтэй Монос Хүнс ХК хамтран Тайлагч бүтээгдэхүүнийг шинээр худалдаанд гаргалаа. Тайлагч нь сортууруулах ундаанаас үүдэлтэй хордлогоос сэргийлж, ШАР ТАЙЛАХ үйлчилгээтэй бүтээгдэхүүн юм. Энэхүү бүтээгдэхүүний худалдан авалт бүр Монголын бүтээлч салбарт хувь нэмэр оруулах болно.



## ААМИ, ТААМИ ШҮҮС ТӨРЛӨӨ НЭМЛЭЭ

“Маамуу” цуврал хүүхэлдэйн киноны гол дүрийн өхөөрдөм баатруудын нэрээр бүтээгдсэн “Аами, Таами” шүүс төрлөө нэмэн тоорын амтат Таами&Жожо, чангаанз болон луувангийн амтат Аами&Өөдөө-гөөр төрлөө нэмлээ. Энэхүү бүтээгдэхүүнийг хүүхэд багачууд өдөр тутамдаа хэрэглэснээр хоногийн С амин дэмийн хэрэгцээгээ хангаж дархлаагаа дэмжин ханиаднаас урьдчилан сэргийлэх боломжтой.



## УВДИСТ ӨТГӨРҮҮЛСЭН ШҮҮС ХУДАЛДААНД ГАРЛАА

Чацаргана болон жүржийн хослол бүхий Увдист шүүс нь витаминь өндөр агууламжтайгаас гадна антиоксидант үйлчилгээтэй. Мөн хэрэглэхэд хялбар савлагаатай бөгөөд 2 литр өтгөрүүлсэн шүүс нь 40-50 аяга шүүс болно.





# САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН


Үзүүлэлт /сая.төг/	2021 он	2022 он	Өөрчлөлт %
<b>ХӨРӨНГӨ</b>	<b>22,996.0</b>	<b>36,507.6</b>	<b>59%</b>
<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>9,818.0</b>	<b>12,472.5</b>	<b>27%</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	258.0	295.5	15%
Дансны авлага	2,880.0	3,586.9	25%
Татвар, НДШ - ийн авлага	73.1	45.6	-38%
Бусад авлага	49.7	181.4	265%
Бараа материал	5,785.6	7,750.0	34%
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	771.5	613.1	-21%
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>13,178.0</b>	<b>24,035.0</b>	<b>82%</b>
Үндсэн хөрөнгө	12,501.3	22,188.4	77%
Биет бус хөрөнгө	591.0	525.8	-11%
Хойшлогдсон татварын хөрөнгө	55.1	70.2	27%
Бусад эргэлтийн бус хөрөнгө	30.6	1,250.6	3987%
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>22,996.0</b>	<b>36,507.6</b>	<b>59%</b>
<b>Өр төлбөр</b>	<b>8,075.0</b>	<b>19,216.9</b>	<b>138%</b>
<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>4,651.3</b>	<b>14,545.7</b>	<b>213%</b>
Дансны өглөг	798.4	1,270.1	59%
Цалингийн өглөг	56.1	178.7	218%
Татварын өр	509.0	1,707.3	235%
НДШ-ийн өглөг	16.3	228.2	1304%
Богино хугацаат зээл	2,676.1	10,584.9	296%
Зээлийн хүүгийн өглөг	20.8	105.9	408%
Ногдол ашгийн өглөг	0.0	0.0	
Урьдчилж орсон орлого	27.8	58.7	111%
Нөөц өр төлбөр	153.7	150.4	-2%
Бусад богино хугацаат өр төлбөр	393.1	261.5	-33%
<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>3,423.7</b>	<b>4,671.2</b>	<b>36%</b>
Урт хугацаат зээл	3,294.1	4,671.2	42%
Бусад урт хугацаат өр төлбөр	129.6	0.0	-100%
<b>Эздийн өмч</b>	<b>14,921.0</b>	<b>17,290.7</b>	<b>16%</b>
Өмч - Хувьцаат	2,318.2	2,318.2	0%
Нэмж төлөгдсөн капитал	6,835.7	6,835.7	0%
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	451.9	410.9	-9%
Хуримтлагдсан ашиг	5,315.2	7,725.8	45%

# ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН


Үзүүлэлт /сая.төг/	2021 он	2022 он	Өөрчлөлт %
Борлуулалтын орлого (цэвэр)	18,840.8	28,216.6	50%
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	10,291.6	15,928.7	55%
<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>8,549.2</b>	<b>12,287.9</b>	<b>44%</b>
Бусад орлого	82.4	74.4	-10%
Борлуулалт, маркетингийн зардал	3,649.7	5,100.6	40%
Ерөнхий ба удирдлагын зардал	1,586.7	2,668.4	68%
Санхүүгийн зардал	616.8	648.7	5%
Бусад зардал	398.1	163.6	-59%
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-52.6	-152.1	189%
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>2,327.7</b>	<b>3,628.9</b>	<b>56%</b>
Орлогын албан татвар	298.0	441.6	48%
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>2,029.7</b>	<b>3,187.3</b>	<b>57%</b>

# ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


Борлуулалтын орлого  
/сая.төг/




Нийт ашиг  
/сая.төг/




Цэвэр ашиг  
/сая.төг/



EBITDA  
/сая.төг/



Хөрөнгө оруулалт  
/сая.төг/



# НИЙГЭМД ҮЗҮҮЛСЭН ЭЕРЭГ НӨЛӨӨ



## Каннын кино наадамд Монгол Улсаас анх удаа оролцож буй хүүхдийн киног ивээн тэтгэлээ

Дэлхийн кино урлагийн салбарын тэргүүн зэрэглэлийн Каннын кино наадам энэ жил 75 дахь удаагаа зохион байгуулагдаж байна. Тус кино наадамд “Том толгойтын адал явдлууд” киноны уран бүтээлчид Марше ду фильм арилжааны хэсэгт хүүхдийн киногоор Монгол Улсаас анх удаа оролцож, Монос Хүнс ХК ивээн тэтгэж хамтран ажиллаа.



## “Зүрхээ хайрлая” өдөрлөг

Эрүүл мэндийг дэмжигч Монос Хүнс ХК-ийн зүгээс нийгэмд тулгамдаад буй өвчлөлийг бууруулахад дэм болох үүднээс жил бүр тухайлсан сургалт арга хэмжээг зохион байгуулдаг. Энэ жилийн арга хэмжээгээ “Зүрхээ хайрлая” нэрийн дор СХНЭ-ийн Хүний их эмч Э.Өнөржаргалтай хамтран 2022.06.02-ны өдөр зохион байгууллаа.



## “Томуугийн эсрэг хамтдаа” өдөрлөг

Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлгийн Нийгмийн эрүүл мэнд, хамтын ажиллагааны албанаас санаачлан Монос Хүнс ХК-ийн дэмжлэгтэйгээр “Томуугийн эсрэг хамтдаа” өдөрлөгийг зохион байгуулав. Тус арга хэмжээний үеэр Монос Хүнс компани Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй 600 орчим хүүхэд, асран хамгаалагчид дархлаа дэмжих нэрийн бүтээгдэхүүнийг гардуулан өгч, жүжигчилсэн тоглолт үзүүллээ. Мөн энэ үеэр СХНЭ-ийн эмч, мэргэжилтнүүд хэвтэн эмчлүүлэгчдэд гараа хэрхэн зөв угааж халдварт өвчнөөс хэрхэн сэргийлэх талаар зөвлөмж, зөвлөгөөг хүүхэд багачууддаа сонирхолтой хэлбэрээр өгсөн юм.



## Тамхины эсрэг өдрийн сургалт

Дэлхий дахинаа жил бүрийн 05-р сарын 31-ний өдрийг “Тамхины эсрэг өдөр” болгон тэмдэглэж тамхины утаа болон хэрэглээнээс үүдэлтэй уршигийг таниулах, эдийн засагт үзүүлэх хор нөлөөллийн мэдээллийг түгээх зорилгоор тэмдэглэдэг. Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран “Тамхины хор уршиг” сэдвийн хүрээнд сургалт хийлээ. Сургалтаар тамхины хэрэглээ, утаанаас үүдэлтэй хор хөнөөл болон тамхинаас ялгардаг бодисын хор хөнөөлөөс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө мэдээллийг хүргэв.



### ЭХЭМҮТ-ийн Ерөнхий мэс заслын тасгийн өрөөг тохижуулла

ЭХЭМҮТ-ийн Ерөнхий мэс заслын тасгийн хүлээлгийн болон үзлэгийн өрөөг иж бүрэн тохижуулж хүлээлгэн өглөө.

Энэхүү 2 өрөө нь жилдээ 13,000 гаруй хүүхэд өөрийн асран хамгаалагчийнхаа хамт төлөвлөгөөт болон яаралтай мэс заслын өмнөх мэдээгүйжүүлэлтийн үзлэг, эмч нарын зөвлөгөөг авч хүнд болон хөнгөн хагалгааны өмнө аав, ээж асран хамгаалагчийн хамт сэтгэл санаагаа бэлдэх, цагийг өнгөрүүлэх зорилготой өрөө юм.



### Маамуутай нэг өдрийг хамтдаа” өдөрлөг

Эрүүл мэндийг дэмжигч Монос Хүнс ХК 10 жилийн ойн хүрээнд Монгол контент ХХК-тай хамтран “Ид шидийн орон 2” хүүхэд хамгааллын төвд “Маамуутай нэг өдрийг хамтдаа” өдөрлөгийг зохион байгуулав. Энэ үеэр 200 гаруй хүүхдэд гарын бэлэг гардуулж, Аами&Таами хүүхдүүдийн хамт нэг өдрийг хөгжилтэй өнгөрүүлсэн юм.



### “ЭРҮҮЛ БИЕЙН ТӨЛӨӨ” сувиллын өдөрлөг зохион байгуулав

Нийгмийн хариуцлагын хүрээнд жил бүр ахмадуудаа чиглэсэн ажлууд зохион байгуулдаг бөгөөд энэ жил “Эрүүл биеийн төлөө” уриан дор Өвөржанчивлан, Аржанчивлан болон Задгай цагаан рашаан сувиллуудаар амжилттай зохион байгууллаа. Тус арга хэмжээнд нийт 170 гаруй амрагч, ажилтан хамрагдсан бөгөөд нийгэмд тулгамдаад буй өвчлөл, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар эмч, мэргэжилтнүүд эрүүл мэндийн зөвлөгөө өглөө.



### Дэлхийн Гепатитын өдрийг тохиолдуулан мэргэжлийн эмч нарт сургалт орлоо

Монос Хүнс ХК жил бүр тус өдрийг тохиолдуулан эрүүл мэндийн байгууллагатай хамтран иргэдэд элэгний өвчлөлөөс хэрхэн урьдчилан сэргийлэх, элэгний өвчлөлд гол хүчин нөлөөлдөг шалтгааны талаар таниулах, мэдээлэх зорилгоор сургалтууд зохион байгуулдаг билээ. Энэ жил Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран “Элэгний хорт хавдар, түүнээс урьдчилан сэргийлэлт” сэдвийн хүрээнд сургалт амжилттай зохион байгууллаа.

# ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



## МФС 2.0 төслийн нээлт болж, барилгын ажлыг эхлүүлэв

Монос Хүнс ХК-ийн “МФС 2.0” үйлдвэрийн шав тавих ёслол болж, төслийн нээлтээ хийлээ. Үг төсөл хөтөлбөр нь компанийн бизнесийн ирээдүйгээ тодорхойлох, хөгжлийн дараагийн үе шатад хөтлөх, хуурай, шингэн хүнсний үйлдвэр болон оффисыг нэгтгэх зорилготой. Төсөл хэрэгжсэнээр үйлдвэрийн хүчин чадал нэмэгдэж халуун, хүйтэн савлагаа болон биологийн идэвхт бүтээгдэхүүний савлагааг нэгэн зэрэг үйлдвэрлэх боломжтой болох юм.



## Байгальд ээлтэй үйлдвэрлэл

Үйлдвэрийн хэмжээнд байгальд ээлтэй эрчим хүч бага зарцуулдаг LED гэрэлтүүлэг, эрчим хүчний хэмнэлт бүхий A+ ангилалын цахилгаан хэрэгслүүдийг ашигласнаар III улиралд 11%-ийн цахилгаан хэмнэлт хийлээ. Мөн саарал усыг өөрсдийн ахуй хэрэглээндээ тогтмол ашиглан, зарим тохиолдолд үйлдвэрийн орчины ногоон байгууламжийн усалгаанд хэрэглэж усны хэрэглээг 7%-аар хэмнэв.



## Монос Хүнс ХК хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа амжилттай зохион байгууллаа

Монос Хүнс ХК хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа 2022 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр Хөрөнгө оруулалтын экспогийн үеэр амжилттай зохион байгууллаа. Хурлыг ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Гантулга даргалж, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн **79.95%** нь хуралд оролцож компанийн үйл ажиллагаатай холбоотой дараах асуудлыг хэлэлцэн батлав. Үүнд:

- Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт хэлэлцэн батлах,
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны төсвийг батлах,
- ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох,



## Монос Хүнс ХК-ийн Дотоод хяналтын лаборатори MNS ISO/IEC 17025:2018 итгэмжлэлээ гардан авлаа

Эрүүл мэндийг дэмжигч Монос Хүнс ХК-ийн Дотоод хяналтын сорилтын лаборатори нь **MNS ISO/IEC 17025:2018** буюу “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага”-ыг хангаж Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын 2022 оны А/29 дүгээр тушаалаар магадлан итгэмжлэгдлээ. Энэхүү итгэмжлэл нь лабораторийн чанарын менежментийн тогтолцоо, техникийн чадавхи, шударга байдал, тууштай үйл ажиллагаа явуулах ерөнхий шаардлагыг тодорхойлдог байна.



### Монос Групп Монгол Улсын Их Сургуулийн “ШИЛДЭГ ТҮНШ”-ээр тодорлоо

МУИС-ийн сургалт, судалгааны үйл ажиллагааны чиглэлд тогтвортой, найдвартай хамтран ажиллагч нартаа олгодог “ШИЛДЭГ ТҮНШ” байгууллагаар Монос групп шалгарлаа. Эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлд гадаад, дотоодын тэргүүлэх их дээд сургуулиудтай Монос групп нь тогтмол хамтран ажилладаг бөгөөд МУИС-тай 2011 оноос хамтран ажиллаж эхэлсэн. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд Монос групп болон МУИС-ийн эрдэмтэн докторууд таван жилийн судалгаа шинжилгээний үр дүнд монголчуудын уламжлалт хэрэглээг орчин үеийн шинжлэх ухаантай хослуулан биеийг хоргүйжүүлэх, антиоксидант үйлдэлтэй “100 наслаарай” цайг 2015 онд зах зээлд амжилттай нэвтрүүлсэн юм.



### Монос Хүнс ХК ТҮЗ-ийн шинэ бүрэлдэхүүнтэйгээ 2022 оны анхдугаар хурлаа хийлээ

Монос Хүнс ХК-ийн энэ оны I улирлын ТҮЗ-ийн ээлжит хурал 2022.05.04 нд амжилттай болж өндөрлөлөө. Хуралд ТҮЗ-ийн гишүүд танхимаар бүрэн бүрэлдэхүүнээр 100%-ийн ирцтэйгээр хуралдаа оролцлоо. Энэ удаагийн ээлжит хурал шинэ бүтэц бүрэлдэхүүнтэйгээр хуралдаж ТҮЗ-ийн дарга болон ТҮЗ-ийн дэргэдэх хороо, нарийн бичгийн дарга нарыг сонгов. Хурлаар тус компанийн 1-р улирлын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, Монос Хүнс ХК-ийн урт хугацааны болон богино хугацааны бизнес төлөвлөгөөний зорилтыг хэлэлцэн батлав.

## МОНОС ХҮНС ХК ЭКСПОРТЫН ЦАР ХҮРЭЭГЭЭ ӨРГӨЖҮҮЛЛЭЭ

Эрүүл мэндийн хүнсний үйлдвэрлэлийн тэргүүлэгч Монос Хүнс ХК нь 2017 оноос хойш экспортын борлуулалтад анхаарлаа хандуулсаар ирсэн.

2022 оны хувьд Орос, Хятад, Америк, Солонгос, Кыргыз улсын зах зээлүүдэд анхаарал хандуулан ажилласан бөгөөд эхний үр дүнгүүд гарч эхэллээ. Австри улсад төвтэй “TSC” компанийн ОХУ дахь салбар “TSC Food Products RU” компанитай хамтран 10 сарын хугацаанд “МИЛИНО” брэндийн ааруултай үрэл бүтээгдэхүүнийг хөгжүүлж эхний нийлүүлэлтийг хийгээд байна. Энэхүү “МИЛИНО” брэндийн ааруултай үрэл бүтээгдэхүүн нь ОХУ-аас гадна Хамтын нөхөрлөлийн холбооны таван улсад борлуулагдах боломжтой болсон юм.


Үүнээс гадна 2021 оны 12-р сарын 16-нд Бүгд Найрамдах Кыргыз улсын Бишкек хотноо тус улсын зах зээлд “Монос Хүнс” ХК, “Монос эмийн үйлдвэр”, “Монос Косметик” ХХК-уудын экспортын үйл ажиллагааг төлөөлөх зорилго бүхий Монос Кей Жей компанийн нээлтээ хийв.



# МФС 2.0 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА



Манай компани нь Хуурай болон шингэн хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд 2022 онд Монос Хүнс ХК-ийн 10 жилийн ой тохиолоо. Энэхүү түүхэн мөчид бизнесийн ирээдүйгээ тодорхойлох, хөгжлийн дараагийн үе шатад хөтлөх, хоёр үйлдвэрээ нэгтгэх үйлдвэрлэлийн “MFC 2.0” төслөө эхлүүлсэн юм.



## МФС 2.0 Төслийн боломж болон давуу талууд:



- Үйлдвэрийн автоматжуулалт



- Үйлдвэрийн хүчин чадал нэмэгдэж халуун, хүйтэн савлагаа болон биологийн идэвхт бүтээгдэхүүний савлагааг нэгэн зэрэг үйлдвэрлэх



- Үйлдвэр-оффисын хосолмол шийдлийг бий болгох ажилтнуудын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх



- Үйл ажиллагаа өргөжиж, борлуулалтын орлого нэмэгдэх




- Шинэ брэнд бүтээгдэхүүнүүдээ зах зээлд амжилттай үйлдвэрлэн гаргах юм.






ҮЙЛДВЭРИЙН  
БАРИЛГА



ТОНОГ  
ТӨХӨӨРӨМЖ



БҮТЭЭГДЭХҮҮН  
ХӨГЖҮҮЛЭЛТ

